

РЕДАКЦИЙН ЗУРВАС

БИ ЗАГАС ШИГ ДУУГУЙ БАЙЖ ЧАДСАНГҮЙ

"Хонх" хамтлагийн дүрмээ

Ардчилсан нам ард түмэнтэйгээ хамт 9 дэх удаагийн ардчилсан сонгуульд оролцоход бэлэн боллоо. 2024 оны Монгол Улсын их хурлын сонгуульд Ардчилсан нам сонгогчдын санал, нийгмийн захиалгыг чагнаж, 210 мянган гишүүнээсээ шилж сонгон 126 нэр дэвшигчээ тодруулав. Ардчилсан үзэл санааг хамгаалдаг, нутаг орондоо элэгтэй, Монгол Улсдаа хэрэгтэй хүмүүсээ илгээлээ. Энэ бол Ардчилсан намд ялалт авчрах 126 нэр дэвшигч, ЯЛАЛТЫН ШИГШЭЭ БАГ юм.

"Би загас шиг дуугүй байж чадсангүй" гэж 35 жилийн өмнө ардчиллын дууч "Хонх" хамтлаг, алдарт С.Цогтсайхан дуулж байсан. "Бид загас шиг дуугүй байж чадахгүй ээ" гэж ард олон маань өнөөдөр хэлж байна. Ардчилсан нам бол УИХ-ын 8 сонгуулийг унаж, босож туулсан улс төрийн туршлагатай хүчин. Ерөнхийлөгчийн 8, орон нутгийн 8 сонгуульд ард түмнээрээ дүгнүүлсэн нам. Алдаа оноо нь ард түмнийхээ өмнө ил байдаг нам. Яагаад гэвэл Ардчилсан нам бол амьдралаас ангижирч тасраад явчигсан дарга нарын нам биш, ард түмнийхээ нэг хэсэг нь юм.

"Хонхны дуу"-тай 1990 оны цагаан морин жил ардчилал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны төлөө эвлэлдэн нэгдэж, эелздэн нягтарч чадсан шигээ энэ удаа улс үндэстнийхээ ирээдүйн төлөө хариуцлагатай сонголт хийх торгон мөч ирлээ. Монголын ардчилал сөхөрсөн бороо тэнийлгэн өндийн босож ирж чадах уу, үгүй юу гэдгийг та бид 6 дугаар сарын 28-нд шийднэ. Хүч тэнцвэргүй энэ удаагийн сонгуульд Ардчилсан намын гишүүд, дэмжигчид, нийт ард түмэн ардчилал, эрх чөлөөгөө хамгаалж, бүтэн, бүрэн авч үлдэхийн төлөө саналаа өгнө.

Цаг эргэж байна. Бүтэн найман жил ард олноо дээрээс харж, "ууны" гэж доромжилсон эрх баригчдыг СОЛЬЁ! Амласнаа биелүүлээгүй, авлига хахуульд орооцолдсон эрх баригчдаас САЛБЯ! Ажил хийдэггүй, худлаа амладаг дарга нарыг ХАЛБЯ!

2024.06.28.

МОНГОЛ ХҮНИЙ САРУУЛ УХААНД ИТГЭНЭ



бүхнээ "нууц" гэдэг том улаан тамгаар дэлдэн хар авдуртаа хав дардаг зураглалтай болсон. Зэмлэстэй үүчин ногоон автобусны 134 тэрбум төгрөгийн худалдан авалт нууц. Парламент хоорондын комиссыг хэн зөвшөөрсөн нь нууц. Их наяаар яригдах "Ковид"-ын төсвийн зарцуулалт нууц. ЖДҮ-ийн зээл далдуур. Нүүрсний гэрээ нууцаар. Хөгжлийн банкны асуудал бүгд хэвлэлийн ард, сөргийн мухарт. Ардчилсан намын санаачилга, амжилттай хэрэгжүүлсэн шилэн дансыг хөтөлбөр төрийн байгууллага, төрийн өмчит компани өнөөдөр байхгүй болсон. Төрийн нуулын зэрэглэл бол хулгайгаа хаахгайлах, луйвраа халхалх бамбай биш. Өглөө болгон утга, угаараас болж амиа алдсан сэтгэгдэл хургэгдсэн тухай модоо уншдаг боллоо. Улаанбаатар хотыг тэр чигээр нь угаартуулж, унтуулах шахсан үнэр юу байсан бэ? Тэр үнэр бол эрх баригчдын илэрхийлэл үнэр юм. Тэр бол авлигын өмхий самхай юм.

СОЛЬЁ!

"ЯГ ТҮҮН ШИГ" - Эрх чөлөө өдөр өдрөөр хуимдаж байна. Ам барилт, тари угаалт Засгийн газрын ажлаа явуулдаг үндсэн арга барил нь болжээ. Төр хэвлэл мэдээллийн хамгийн том санхүүжүүлэгч, хамгийн том реклам өгөгч болоод удаж байна. Сүр дүүлэгтэй аян, хөтөлбөр, өдөр бүр шахуу төрийн ордонд болдог элдэв янзын үндэсний чуулганууд амьдрал сайжирдаг бид бид бус нутаг, тив дэлхийгээ хол хаяхаар болсон. Төрийн санаачилсан төрөөс санхүүжүүлж, төсвийн мөнгөөр хийж байгаа энэ олон сүрхөн ажлын өртгийг татвар төлөгч бид төлж байгаа. Эргэдэг иргэний мэдэх эрх зөрчигдэж, хэвлэл мэдээллийн хараат бус байдал алдагдаж байна. Сөрөг хүчнээ гутган харуулж, улс үндэстнээ талцуулан хувааж байгаа МАН-ын дарга нар ялалт, амжилт дүүрэн гэж "Яг түүн шиг" шогт засгийн толгойд тоглож байна.

СОЛЬЁ!

НАЙМАН ЖИЛ... Энэ чинь бараг 3000 өдөр. Харин бид даргаа, гишүүнээ, эрх барьсан намаа огт солиогүй. Солиогүй, салаагүй найман жил. Дарханы замыг барьж бараагүй 8 жил. 6 дугаар сарын 28 бол ард түмнийхээ амны хншгийг эрхсэн, эрх баригчдын зайгүй ажигласан 8 жил завсарлах өдөр. 6 дугаар сарын 28...

Дарганаар даварч, "ууны" ард нь цөхөрсөн 8 жил. Утаандаа үхэцгээж, түгжрэлдээ өтөлцөөсөн 8 жил. Хулгайд нам дарлуулж, луйварт нүд дассан 8 жил. Ахиад 4 жил алдвал нэг намын завсаргүй засагласан 12 жил болно. Гэхдээ зовхи нь өөдөө монгол хүн бурангуй цагийг эргүүлж, салхи ороогүй, аялалт биелээгүй 8 жилийн араас агшсан, хүлээсэн, айсан 4 жил ахиад залгахгүй. Бид монгол хүний саруул ухаанд итгэдэг.

СОЛЬЁ!

ӨРИЙН ДАРАМТ. Татвар төлөгчдийн мөнгөөр буруу бодлого явуулж байгаагийн дүнг амьдрал гэдэгхатуу багш тавиад өгч байна. 200-гийн цагаан тор дүүрэхгүй хүнс 100 мянган төгрөгт хүрч байгаа тухай дэлгүүрийн кассан дээр айлын эзэгтэй шогшорон ярьж байна. Ломбардад тавьсан пүүзээ (үнэт эдлэл, гар утас биш, хуучин гутлаа шуу!) авч чардахгүй хоёр сар болсондоо оюутан хархүү харамсах байна. Ирэх сарын ипотекийн зээлээ төлөхөө бодлоод идэх үүхээ танаж байна гэж залуу гэр бүлүүд санаа алдан хэлж байна. Монголчууд ломбардад банканд өртэй байна. Компаниуд эзэлийн хүү, татварын өрөндөө өөдөг сохорч байна. Улс нь гадаад өрөө өсгөн нэмсээр, өрийг өрөөр дарсаар байна. Өнөөдрийн амьдрал маань өрийн тойрогт орсон. Иргэн бүрийг 33 сая төгрөгийн өртэй болгосон эрх баригчид энэ сонгуульд ичиггүй ахиад 12

жил болгоод сонгоод өг гэдэг ирлээ.

СОЛЬЁ!

"УУНЫ" АМЬДРАЛ. Орлого нь буурсан таксины жолооч, ашиг нь алдагдсан ГҮЦ-ийн худалдагч, мал нь цөөрсөн малчин, өр нь өссөн иргэний өмнөөс Ардчилсан нам сонгуульд оролцож байна. Чадлаараа, мөрөөрөө амьдралаа яваа малчин, худалдаачин, төрийн албан хаагчдын өмнөөс Ардчилсан нам 2024 оны сонгуульд оролцож байна. Алдагдсан 8 жилийн алдааг засах гэж ардчиллын охид, хөвгүүд сонгуульд өрсөлдөж байна. Нөгөө талд нь ард түмнээ "Ууныхан" гэж доромжилсон дарга, гишүүд, эрх баригчид биелээгүй аялалт, хүрээгүй зорилтоо ахин дахин ярьсаар л...

СОЛЬЁ!

ДАНХАР ТӨР. МАН засагласан цаг үе бол төрийн

бизнес томорч, хувийн хэвшил жижигхэрсэн 8 жил байлаа. НВАТ болоод орлогын албан татвартай холбоотойгоор 100 мянган иргэний санал УИХ-д хаяглагдан ирсэн ч таг чиг, нам хям. Татвар нэмэхгүй гэж аялалт өгөөд гарч ирсэн эрх баригчид ичиг ичиг Улсын нэгдсэн төсвийн орлогын 80 гаруй хувийг та бидний татвараар бүрдүүлдэг. Түүхэнд байгаагүй 20 гаруй сайдтай Засгийн газрыг ингэж бид тэжээдэг юм.

СОЛЬЁ!

ХАРИУЦЛАГАГҮЙ ЗАСАГ. Гурван засаг, хоёр сайд, 7 жил дамжсан замыг хэзээ ашиглалтад оруулах вэ гэж Дархан, Эрдэнэтийнхэн асууж байна. "Арал дээр амьдарч байгаа юм шиг зээг хаягдсан даа" гэж Дарханыхан ярьж байсан цаг бий. Дарханы замын осол фронтын мэдээ шиг хүнд болсон. Хар толгойгоороо хариуцна гэсэн сайд, дарга нараас хариуцлага хүлээсэн албан тушаалтан байна уу? Энэ дээр бид алджээ гээд эрх баригчид үүчлалт гүйсэн үү? Үгүй, Үгүйгээр барахгүй улаан тууз, хайчаа барилд, даралгийн "цавчаа" руугаа ингээд очиж байна.

СОЛЬЁ!

ХУУЛЬЧИЛСАН ХУЛГАЙ. Завсаргүй засагласан 8 жилд эрх баригчид луйвар, хулгай

Г. ГАНБААТАР

БҮТЭН АРДЧИЛЛЫН ТӨЛӨӨ БҮРЭН САНАЛАА ӨГӨӨРЭЙ



Эрхэм сонгогч та хоёр саналын хуудас бөглөнө. Нам, эвсэлд өгөх саналын хуудсанд та өөрийн дэмжиж байгаа нэг л намыг, тухайлбал АРДЧИЛСАН НАМЫН нэрийн өмнөх зууван дугуйг дүүргэн будаарай. Харин хоёр дахь саналын хуудсанд та тухайн тойргийн мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг, тухайлбал Ардчилсан намын бүх нэр дэвшигчийн өмнөх зууван дугуйг дүүргэн будаж, БҮТЭН АРДЧИЛЛЫН төлөө саналаа өгөөрэй.



9+ ЗОРИЛТ
9000+ АЖИЛ
9000+ ЗААЛТ

...

...Авлига,
шударга
бус байдал,
дарангуйлал,
ард түмнээ
алагчлах
үзэл эцэстээ
бусдын идэш
болоход
хүргэдэг
гашуун түүх
бий...



Л.ГАНТӨМӨР: ЭРХ БАРИГЧДЫН ИРГЭДЭЭСЭЭ БУЛААСАН БОЛГОНЫГ ЭРГҮҮЛЖ АВЧИРНА

Ардчилсан намын дарга
Луванснямын Гантөмөртэй
ярилцлаа.

-Та энэ сонгуульд зайлшгүй
ялах шаардлагатай гэж ярьж
байгаа. Үүнийгээ дэлгэрэнгүй
тайлбарлаач...

-Зөвхөн нам ялж хэдэн хүн
дарга болох гээд байгаа юм
биш. Улс үндэстний эрх ашиг,
эрх чөлөө, ардчилал орших, эс
орших дээрээ тулсан эгзэгтэй
цаг үе тохиож байна. Шүүмжлэн
хэлэхэд улс орны тусгаар
тогтвор, аюулгүй байдлаа
холбоотой. Дэлхий дахины улс
төрийн байдал түгшүүртэй, дайн
байлдаантай байгаа энэ эгзэгтэй
үед эдийн засаг, хүний эрх, эрх
чөлөө алдагдаж, дарангуйлал
руу гулсаж байгаа нь ийм
болгоомжилол төрүүлж байна.
Үүнийг зөвхөн би хэлээд байгаа
юм биш, дэлхийн хэмжээний улс
төрд ч шинжээчид ярьж, бичиж
байна.

Авлига, шударга бус байдал,
дарангуйлал, ард түмнээ
алагчлах үзэл эцэстээ бусдын
идэш болоход хүргэдэг гашуун
түүх бий. Ардчилсан нам ийм
эгзэгтэй цаг үед ялалт байгуулж
улс гэрээ өөд нь татаж, хүн
зонхноо амьжиргааг
дээшлүүлж, хөгжлийн зөв зам
дээр гарах ёстой. Бид Монголын
ардчиллыг бүрэн, Монгол Улсаа
бүтэн байгалийн төлөө эцсээ
хүртэл зогсож болно. Эдийн засаг
ч бүрэн доройтож, гадна өрийн
хэмжээ хоёр дахин нэмэгдэж,
34 тэрбум ам.долларт хүрлээ.
Монголчуудын хүнсний гол
хэрэгжээ болох хойны махны үнэ
2016 онд 67 нь 5000 төгрөгт байсан
бол өнөөдөр 15900 төгрөгт хүрч,
гурав дахин нэмэгджээ. Энэ
мэтчилэн тооцоод байвал дандаа
л үнийн өсөлт, ядуурал гэсэн
таагүй үзүүлэлтүүд гарна.

-Нөгөө талд эрх баригч нам
бас л завсрал ялах шаардлагатай
гээд амь тэмцэж байх шиг. Тийм
ч учраас таний намыг хэдэн сар
бэлбэх шиг боллоо...

-Тэд ялж явах гээд байгаа юм.
Улам, ногоон автобусныхаа
хулгайг үргэлжлүүлж гээд байгаа
юм уу? "Эрдэнэт үйлдвэр"-ийг бүр

хоосолж, Тавантолгойг нэгмөсөн
самрах гээд байгаа юм уу?
Үнэхээр амь нь тэмцэж байна. Тэд
цөтгөрийн тойрогт орчихсон. Гарч
чадахаасаа өнгөрсөн.

Цөтгөр бүрхэн болдоггүй
учраас цөтгөр хэвээрээ л
дуусахаас өөр аргагүй. Хулгай нь
илэрчих вий, худал нь мэдэгдчих
вий, иддэг, уудаг нь багасчих
вий гэж айгаад төрөөс зайлж
чадахгүй байгаа юм. Тэд ялбал улс
орон нэгмөсөн сүйрнэ. Ганцхан
жилийн дараа л хар автобусны
сонсол, "Шинэ хоршоо"-ны
сонсол гээд л суух байх вий.
Эрх баригчдад ажил хийх боломж
хангалттай байсан. Экспортын
гол нэрийн бүтээгдэхүүн болох
ээс, нүүрсний үнэ дэлхийн зах
зээлд 2-10 дахин өсөж, урьд өмнө
тохиолдож байгаагүй таатай
боломжууд бий болсон. 2015
онд үүл үүрхэйн бүтээгдэхүүний
экспортын хэмжээ 4.6 тэрбум
ам.доллар байсан бол 2023 онд
15 тэрбум ам.долларт хүрсэн.
Энэ мөнгө хаачив, хэнд наалдав
гээд асуултууд гарна аа даа.
Наймын найман жил үнэмлэхүй
олонхоор төр барьсан хэрнээ
хүн зонх амьдралд нөлөөлөх, улс
орноо өөд нь татах ганц ч ажил
хийсэнгүй. Дарханы замыг найман
жил тавиад дуусгасангүй. Энэ бол
алдагдсан найман жил, хайран
байгаа биз. Тэд хийсэн ажилгүй,
хэлэх үггүй болохоороо олны
анхаарлыг өөр тийш хандуулж,
тархи угааж байдлаар эрээгүй
дөвтөлсөнгөөр байгааг ард түмэн
ойлгож байгаа.

-Эрх баригчид нэг хунд
ногдох ДНБ-ий хэмжээ 5000
ам.долларт хүрсэн гэж
сурталчилж байна. Энэ нь
ард түмний амьдралд хэр
нөлөөлсөн бол?

-Иргэдийн амьжиргаа
дээшлэхгүй бол хий хоосон
тоо яриад нэмэргүй. Би харин
бодитой хэдэн тоо хэлье.
Өнгөрсөн оны эцсээр аж ахуйн
нэгжийн орлогын албан татвараа
тайлагнах ёстой 218 мянган
аж ахуйн нэгжээс 155 мянга нь
төвлөнгөө өгсөн. 63 мянган аж
ахуйн нэгж үйл ажиллагаагаа
зогсоосон тул тайлан өгөөгүй. 70
мянган аж ахуйн нэгж "Х" тайлан
гаргасан гээд бод доо. Энэ хоёр
тоог нэгтгэхээр 133 мянган аж

ахуйн нэгж дамлуурчээ. Дэлхийн
банк, Үндэсний статистикийн
хорооноос 2022 оны ядуурлын
түвшний судалгаа гаргахад 938
мянган иргэн нэн ядуу гэсэн
дүн гарсан. Одоо энэ тоо сая
хол давсан л даа. Дөнгөж төрж
байгаа нярайд 33 сая төгрөгийн
өр шүүд ногдож байна. Тоо худал
хэлэхгүй. Энэ бүхнийг МАН гэнэт
цэгцлээд сайхан болгохоосоо
өнгөрсөн. Хүн зонх улс оронд
маань өөр бодлого, өөр сонголт,
өөр ирээдүй хэрэгтэй байна. Бид
алдагдсан найман жилийн алдааг
засах зоримог шинэчлэл хийх
болно.

-Таний нам сонгуульд ялбал
ажлаа юунаас эхлэх вэ?

-Эдийн засгийн эрх чөлөөг
иргэддээ олгохоос эхэлнэ.
Бизнес хийж, хөдөлмөр эрхэлсэн
хүн бүр үр ашиг хүртэж, амьдрал
ахуйгаа өөд нь татах боломжийг
нь олгоно. Үүний тулд татварын
дарамтыг багасгаж, төрийн
оролцоог хумина. Мөн хувь хүний
заяагдмал эрх болох үг хэлэх,
үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн
нийтлэх эрх, эрх чөлөөг нь буцаан
олгоно. Бидэнд бас нэг том амбиц
бий. Эх орноо шинжлэх ухааны
улс болгомоор байна. Үүний
тулд Шинжлэх ухааны паркийн
түхэй хууль баталж, технологийн
паркууд бий болгоно. Япон,
Өмнөд Солонгос, Хятадын хөгжил
ингэж л эхэлсэн. Би сайд байхдаа
хоёр гурван парк байгуулсан,
одоо үгүй болсон байна лээ.
Дээр нь дэлхийн жишигт нийцсэн
лабораториудыг байгуулна. Гений
эмчилгээ хийж байна гээд худлаа
яриад байх юм. Гений судалгаа
хийж чадахгүй байж эмчилгээ
хийнэ гэж юу байх вэ дээ. Тэдэнд
сэтгэл ч алга, боловсрол, мэдлэг
ч алга. Боловсрол, эрүүл мэндийн
салбарын бодлогоо шинэчлэх
гээд мөн ч их ажил байна.

-Энэ бүхнийг тийм амархан
шийдэж чадах уу?

-Чадалгүй яах вэ, хийе гэсэн
хүсэл байвал болно шүү дээ.
Манай намын мөрийн хөтөлбөрт
энэ бүх ажил заалт нэг бүрээрээ
туусан байгаа. МАН-ыг манайхан
руу дайрч доромжилж байх
зүрч бид салбарын эрдэмтэн,
судлаачид баг бүрдүүлэн мөрийн
хөтөлбөрөө боловсруулж, хийх
ажлаа төлөвлөсөн шүү дээ. Тийм

ч учраас 9 арилт, 90 ажил, 900
заалт бүхий "Эрчимт хөгжлийн
төлөвлөгөө" боловсруулсан.
Манай намын мөрийн хөтөлбөрт
хотын утаа, түгжрэлийг шийдэх,
хашаандаа сайхан амьдрах мал
аж ахуйн хөгжил шинэчлэл гээд
хүний хэрэгцээ цөм багтсан.
Ялчихаад яахаа мэдэхгүй, барьц
алдахгүй, ажилдаа шууд орно
гэсэн үг.

Эгэл жирийн иргэдээс
булавсан болгоныг бид буцаан

бодлого хэрэгжүүлээд нүүдлийн
мал аж ахуй нь устгах дээрээ
тулаад байна. Бусдын төдийгүй
бидний өөрсдийн ч ийм алдаа
байгаа шүү дээ. 1930-аад оны
хамтралжуулалт, нэгдэлжих
хөдөлгөөн гээд туулсан замруугаа
буцах гээд байна. Хөгжсөнгүй улс
орнуудын туршлагыг харж дагаж
яагаад болдоггүй юм Малаа
яаж маллахаа марксизмаар
залгажгүй гэсэн шүлэг байдаг
байх аа. Малчдын малыг барж,
модыг нь барилбал Монгол Улс,
монгол үндэстэн орших, эсэх
нь эргэлзээтэй болно. Гэхдээ
монголчууд хэрсүү болсон.

-Ардчилсан нам залуусаа
хэрхэн дэмжиж байгаа вэ.
Залуус руу чиглэсэн ямар
бодлого хэрэгжүүлэх вэ?

-Залуучууд улс төрийн
манлайлал үзүүлэх ёстой. Тийм
учраас манай нам 30 хүрээгүй
залуусыг нарийн бичгийн даргаар
томилж итгэл үзүүлсэн. Эдгээр
залуус үеийнхэндээ манлайлал
үзүүлж, дуу хоолой нь болж явсаар
гэсэн хүсэл, бас бодлого маань
энэ. Залуу үе намын удирдлагад
байж гэмээнд үеийнхэн рүүгээ
чиглэсэн бодлого боловсруулна.
Боловсруулж чадсан. Залуусаа
гадаадад сургаж, гэр бүл болж
амьдрал ахуйгаа зохиох таатай
нөхцөл бололцоо бий болгох гэж
мөрийн хөтөлбөртөө тусгасан.

-Хэлсэн зорьсондоо хүрч,
хийж бүтээх л үлдлээ?

-Ардчилсан нам чадна аа. Бид
юу хийж, юуг бүтээх, улс гэр,
хүн зонхноо хэрхэн хөгжүүлэхээ
төлөвлөхөөсөн. Хийж чадна
гэдэгтээ ч бүрэн итгэлтэй байгаа.

Бид лоозондоод, тууз
хайчилдаг, шоу үзүүлбэрээр нүд
хуурдаг хийдэг нам биш. Ахар
богино хугацаанд амжуулж
хийсэн ажил Ардчилсан намд
арвин бий. Ипотайн эзэл,
3000 км засмал зам, 40 мянган
айлын орон сууц гээд санзачилж
хэрэгжүүлсэн бодит ажлын
гэсгээлт үрт үргэжилдэг. Энэ
удаад ч бидэнд хийх ажлын тов
тодорхой төлөвлөгөө байгаа.
Тийм ээ, БИДЭНД ТӨЛӨВЛӨГӨӨ
БАЙНА. Төлөвлөгөөний маань нэр
"9+90+900".

Ярилцсан Б.ГАНХУЯГ

АРДЧИЛСАН НАМААС УИХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ТОЙРОГТ НЭР ДЭВШИГЧИД

АЖИЛ ХИЙХ АРДЧИЛЛЫН 78

ТОЙРОГ 1



Дашондогийн
ГАНБАТ



Оюунсайханы
АЛТАНГЭРЭЛ



Амгалантуйн
АДЬЯАСҮРЭН



Пүрэвбаатарын
МӨНХТУЛГА



Даваагийн
ЦОГБААТАР



Сайхүүгийн
ГАНБААТАР



Ганбатын
ХОСБАЯР



Дамдинсүрэнгийн
ЖАРГАЛСАЙХАН



Энхбишийн
БОЛОРЧУЛУУН

ТОЙРОГ 8



Түмэндэлгүүрийн
БАТЦОГТ



Ганболдын
БОЛОРМАА



Майнбаярын
ТУГАТ



Цагаан-Өгөөний
ЖАДАМБАА



Ганболдын
УУГАНЦЭЦЭГ

ТОЙРОГ 2



Одонгийн
ЦОГТЭРЭЛ



Бөхчулуны
ПҮРЭВДОРЖ



Очирбатын
АМГАЛАНБААТАР



Загдхүүгийн
НАРАНТУЯА



Ширэнбаяндын
АДЬШАА



Догсомын
БАТЦОГТ



Цогтоогийн
ОДОНТУГАЛАГ



Даймаагийн
БАТСАЙХАН



Банзрагчийн
ТҮВШИН



Норовын
ТЭГШБАЯР

ТОЙРОГ 9



Содномундуйн
ЭРДЭНЭ



Цэрэндүлэмын
АЛТАНЦЭЦЭГ



Цэдэйн
ТАВАНЧУЛУУ

ТОЙРОГ 10



Чадраабалын
ӨНӨРБАЯР



Ишжамцын
МӨНХАРГАЛ



Хөххүүгийн
БОЛОРМАА



Давасүрэнгийн
БАДАРСАН




Цэндийн
БААТАРХҮҮ



Огтбайрын
БААСАНЧУУ

ТОЙРОГ 3



Булан
БЕЙСЕН



Шаривын
ЖАНДОС



Хукейгийн
ДАРМЕН

ТОЙРОГ 4



Халтмаагийн
БАТТУЛГА



Ариун-Эрдэнэ
БАТБААТЫН



Эрдэнэбатын
ХАШ-ЭРДЭНИЙН



Батзандын
ЖАЛБАСҮРЭНГИЙН



Гунгажавын
ЦЭРЭНДОЛГОР



Мөнгөнхуяг
Гүнширийн



Өсөхбаяр
ДОРЛИГИЙН



Хайчаагийн
БАТСАЙХАН

ТОЙРОГ 11



Алтанхуяг
НОРОВЫН



Отгонбаяр
ЖАМБААГИЙН



Амаржин
НЭМХБААРЫН




Цогтэрлийн
УЯНГА



Галиндзав
ПҮРЭВДОРЖИЙН

ТОЙРОГ 5



Тувдаан
ЦЭВЭГДОРЖИЙН



Эрдэнэболд
СҮХБААТАРЫН



Үүрийнтуяа
ДОМБОНГИЙН



Далайн
БАТБАЯР



Одонгуа
НЭМЭХЭГИЙН



Эрдэнэбат
ДОНДОГДОРЖИЙН



Эрдэнэсүвд
ДЭРЭМИЙН



Доржпүрэв
ДУЛАМСҮРЭНГИЙН



Батжаргал
РАДНААГИЙН



Одбаяр
ЛХАСҮРЭНГИЙН

ТОЙРОГ 12



Эрдэнэ-Очирын
ТАМИР



Чулуунбилэгийн
ЛОДОЙСАМБУУ



Бямбын
АРИУНБОЛД

ТОЙРОГ 13



Алтанхуяг
ДАШЗЭВИЙН



Цамбагавын
ГАНАГИЙН

ТОЙРОГ 6



Ганбал
НАЯНТАЙН



Пүрэвхатан
ТӨРМӨНХИЙН



Төмөрхүү
СҮХБААТАРЫН



Бямбасүрэн
ШИНЭБААРЫН



Балдан
ДЭМБЭРЭЛВЭАНЧИГИЙН



Батдэлгэр
ШАГДАРЫН



Төмөрбаатар
ЭРХӨМБААТАРЫН

ТОЙРОГ 7



Ганбаатар
ГОМБЫН



Сэддорж
РЕНЧИЯАМБИЙН



Эрдэнэбүрэн
РАВЖИХЫН



Мөнхбаясгалан
ЛУВСАНБЯМБААГИЙН



Мөнхбат
ЦАГААНХҮҮГИЙН



Одсэр
ЛУВСАНДОРЖИЙН



Энхбат
НАСАНБҮРИЙН

АРДЧИЛСАН НАМ

126

НЭР ДЭВШИГЧИЙН

102

ШИНЭ ЗАЛУУ

Салбар салбартаа мэдлэг, чадвараараа түүнээ болсон 102 цөө шинэ залуу нэр дэвшигч

24

ТУРШЛАГАТАЙ

УИХ, Засгийн газрын түвшинд ажиллаж байсан, ард түмний итгэлийг даах, туршлагатай 24 нэр дэвшигч



САЛХИ ОРУУЛСАН ЖАГСААЛТ

Парламент бол аливаа улсын нийт иргэдийг төлөөлсөн хураангуй юм. Ардчилсан нам эдийн засагч, багш, эмч, инженерүүдээс бүрдсэн, залуу үе, туршлагатай улс төрчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг жагсаалтаар нэр дэвшүүлээ. Нийт 48 нэр дэвшигчийн 19 нь эмэгтэй, 29 нь эрэгтэй, хамгийн залуу нь 27 настай ид гялалзаж яваа шинэ

үеийн төлөөлөл. Залууст нэр үзүүлдэггүй дээрэнгүй хандлагад Ардчилсан нам цэг тавьж, салхи орууллаа. Залууст эрхээ эдлэх, ачаа үүрэх үүдийг цэлийтэл нээв. Нэр дэвшигчийн 40 хувь нь өндөр хөгжилтэй Япон, АНУ, Германд боловсрол эзэмшсэн хуульч, эдийн засагч, багш, төрийн болон бизнесийн удирдлагаар мэргэшсэн доктор, магиструуд. Жагсаалтын 48-

аас 20 нь Японы Осакагийн их сургууль, Сэндай коллеж, Германы Карлсруэ хотын их сургууль, АНУ-ын Индианагийн, Оксфордын, Жорж Вашингтоны, Бриджпортын, Стэнфордын их сургуулийн төгсөгчид. Өнгөрсөн 8 удаагийн УИХ-ын сонгуулийн улс төрийн намуудаас нэр дэвшигчидтэй харьцуулж үзвэл Ардчилсан нам энэ удаа эрс шинэчлэл хийж чадлаа.


АРДЧИЛСАН НАМААС УИХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ЖАГСААЛТААР НЭР ДЭВШИГЧИД

АЖИЛ ХИЙХ АРДЧИЛЛЫН 48



НЭР ДЭВШИГЧДИЙН СТАТИСТИК

ХҮЙСИЙН ХАРЬЦАА



МЭРГЭЖИЛ



БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ



ГАДААД УЛС ОРОНД СУРАЛЦАЖ ТӨГССӨН



МОНГОЛЫН "ЗА" АНДГАЙ БУЙ ЗА... АМЛАЛТ БОЛ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЯАГААД ГЭВЭЛ:

АРДЧИЛСАН НАМ БОЛ

- ▲ АВДАГ БИШ ӨГДӨГ НАМ
- ▲ ӨМЧ ХУРААДАГ БИШ ХУВЬЧИЛДАГ НАМ
- ▲ ТАТВАР НЭМДЭГ БИШ БУУРУУЛДАГ НАМ
- ▲ ЭРХ ЧӨЛӨӨГ ХУМЬДАГ БИШ ТҮГЭЭДЭГ НАМ



“

Ардчилсан намын мөрийн хөтөлбөр "Эрчимт хөгжлийн төлөвлөгөө" нэртэй.

Заавал хүрэх
9 гол зорилт.

ард нь гарах
90 үндсэн ажил.

нарийн төлөвлөсөн
900 дэд заалттай
хөгжлийн төлөвлөгөө.

Гэрэл зургийг Б.ЧАДРААБАЛ

"Утааг ялав", "Иргэдийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг 2 дахин бууруулна", "Татвар нэмэхгүй", "Зээлийн хүүг багасгана", "Шатахууны үнийг 20-30 хувиар бууруулна..."

"Хүчээ нэгтгээ!" уриатай улс төрийн хүчний сонгуулийн амлалтыг та санаж байна уу? Цаг хугацаа хоржоонтой. Он цаг өнгөрлөө ч цаасанд үлдсэн мөр, дэлгэцэд хадагдсан бичлэг баримт болон үлддэг. Ой санамж ахархан байж болох ч хэлснээ хэрэгжүүлдэг нь хэн бэ гэдгийг сануулах үүднээс өнгөрсөн цаг руу бяцхан аялал хийцгээе...

ЕРДӨӨ ХОЁРХОН ЖИШЭЭ:

■ 2012-2016 онд Ардчилсан нам аймгуудыг нийслэлтэй авто замаар холбоно гэсэн амлалтаа 100 хувь биелүүлсэн. Ардчилсан нам засаглаж байхад 3000 км авто зам тавьсан бол өнөөгийн эрх баригчид өнгөрсөн найман жилд 300 км зам ч тавьж чадсангүй. Дарханы зам уу? Цааш нь ярих шаардлагагүй биз.

■ Ардчилсан нам анхлан урт хугацаатай, бага хүүтэй ипотекийн зээлээр иргэдээ орон сууцжуулна хэмээн амлаж байлаа. 2012-2016 онд засгийн эрх барих хугацаандаа 80 мянган айлыг шинэ орон сууцад оруулжээ. Тэгвэл өнөөгийн эрх баригчид

өнгөрсөн 8 жилд үүнээс 2 дахин бага буюу ердөө 40 мянган айлыг орон сууцжуулжээ. Ардчилсан нам 4 жилд 80 мянган айл, МАН 8 жилд 40 мянган өрх...

■ Ардчилсан нам хэлснээ хийдэг, амласнаа биелүүлдэг гэдгийг анзаарч нотлох хоёрхон баримт энэ. Мал хувьчилсан, хүүхдийн мөнгө олгодог болсон, чөлөөт эдийн засгийг дэмжсэн, авлига, хулгайн үүр болсон төрийн өмчийг хувьчилсан гээд амлалт-ажил, зорилт-биелэлтийн жагсаалт урт.

Ардчилсан намын итгэл үнэмшил бол даргын шийдвэр биш, хуулийн засаглал. Ардчилсан нам төрийн дарангуйлал бус, хувь

хүний эрх чөлөөний талд зогсдог. Ардчиллагчид хувийн өмчит, олон тулгуурт эдийн засгийн төлөө байдаг. Иргэндээ ээлтэй эдийн засгийг бүтээх, чөлөөт эдийн засгийн чиг баримжаа бол хөгжлийн стратеги нь юм. Төрийн аль болох бага оролцоотой чөлөөт өрсөлдөөн бол тэдний зарчим. Татварын дарамтыг багасгах, ажлын байр бий болгох, иргэд, аж ахуйн нэгжүүдээс өсгөх, чадавхижуулах зорилго Ардчилсан намын.

Мөрийн хөтөлбөр гэдэг мөрөөдлийн жагсаалт биш. Улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр бол засгийн эрхийг авбал заавал хийх ажлын жагсаалт, бодит төлөвлөгөө байх ёстой. Тийм ч учраас 2024 оны УИХ-ын сонгуульд оролцож байгаа Ардчилсан намын мөрийн хөтөлбөр "Эрчимт хөгжлийн төлөвлөгөө" нэртэй. Заавал хүрэх 9 гол зорилт, ард нь гарах 90 үндсэн ажил, нарийн төлөвлөсөн 900 заалттай хөгжлийн төлөвлөгөө.

Сүүлийн хэдэн жил улс орон өдрөөс өдөрт хөгжин цэцэглэж буй тухай эрх баригчид ярьж

байна. Тэдний амлалт биелдэгсэн бол улаанбаатарынхан өнөөдөр бүгд орон сууцад орж, ажилдаа метрогоор зорчиж байх байлаа. Тэдний ам, ажил зөрдөггүйсэн бол аймгийн төвүүдэд үйлдвэр сүндэрлэхсэн байлгүй яах вэ. Малчид маань өнөөдөр банкны барьцаан дахь хэдэн ямаанаасаа ноолуур гарахыг хүлээж суухгүй л байх. Дарга нарын сүүлийн 8 жил амлаж, ярьсан нь биелсэн бол хэний хүн миний ажлыг авах бол гэж төрийн албан хаагчид маань сонгууль бүрийн дараа сэмхэн түгшиж суухаа больсон байх ёстой.

Эрх баригчид өөрсдөө өрмийг нь авч идчихээд иргэддээ хүсмыг нь тараахдаа өрийн дансыг л зузаалчээ.

Яг л жирийн иргэн жижиг дэлгүүрт өр гээд нэрээ бичүүлж, үнх мах авадаг шиг...

Эгэл иргэд, жирийн монгол хүн асууж байна. Маш энгийн хэдхэн асуулт...

• Гэр хороололд хөгжил дэвшил, хүний наад захын хэрэглээ, тохижилт хэзээ очих вэ?

• Орон сууцад орох

иргэдийн маань мөрөөдөл хэзээ биелэх вэ?

• Ингэхэд Дарханы замыг хэзээ ашиглалтад бүрэн оруулах юм бэ?

• Монгол Улс модон жорлонгоосоо хэзээ салах вэ?

• Хэдий болтол малчид нь ноолуурын ханц, улс нь нүүрсний үнээс хамаарч амьдрах вэ?

• Гэснээс орон сууцад халуун ус хэзээ ирэх вэ?

• Найрлаж дуусаад шартах шиг, дайрч ирэх маргаашийн хүнд өдрүүдийг Монгол Улс хэзээ яах давах вэ?

"ХЭЗЭЭ?" гэдэг ийм энгийн асуултад бултаж булзааруулахгүй хариулж чаддаг төртэй байхын тулд 6 дугаар сарын 28-нд ӨӨР СОНГОЛТ хийнэ. Алдагдсан 8 жилийн алдааг засна. Дөрвөн жилийн дотор буюу 2028 он гэхэд монгол хүний амьдралын түвшнийг эрс сайжруулж, хувь хүний эдийн засгийн эрх, эрх чөлөөг баталгаажуулан шударга ёс төлөвшсөн, гэрэл гэгээтэй нийгмийг бүтээх болно.

Ш.ОТГОН-ӨЛЗИЙ

ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН

9 ЗОРИЛТ

1 Татвар бууруулна. Төсвийн зардал танана. ✓

2 Утааг устгана. Түгжрэл бууруулна. ✓

3 Ипотекийн зээлийн хүүг бууруулж, сарын төлөлтийг багасгана. ✓

4 Тог тасрахгүй, шатахуун тасалдахгүй болгоно. ✓

5 Зудад зутардаггүй чинээлэг малчин. ✓

6 Хүссэн газраа хүрэх 3000 км авто зам. ✓

7 Хашаандаа сайхан амьдарна. ✓

8 Авлигын ялын бодлогыг гурав дахин чангаруулна. ✓

9 Хотын даргаа иргэд сонгоно. Яамдын тоог цөөлнө. ✓



АЛААГСАН Ө НӨЛӨЙН
АЛДААГ ЗАСНА!

ЭРХ БАРИГЧДЫН МОЛИГО

сонгогчид хамт

Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш
Биеийн дээдт хамнараар хийгдсэн цааш
Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш
Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш
Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш
Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш
Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш
Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш
Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш
Хэцүү дээдт хамнараар хийгдсэн цааш

АМЛАЛТ

Аймаг бүрээр
Баягуулах 30,000 ажлын
байгууллага байгуулна.

Хятадын мэдээлэл
үйлдсээрээ өөр өөр
үйлдсээр нэгддэггүй.
Ажлын байр орогдсон.

АМЛАЛТ

30-ийн хувь бууруулж,
хугацааг уртасгана.

Арилжааны банкны
эээлийн хүү жилийн
17% болж нэмэгдэв.

АМЛАЛТ

Гэрээний бизнес эрхлэгч
зюутан, залуусын бизнесийг
дэмжинэ.

Судалгаагаар залуусын
50-наас дээш хувь
нь гадагшаа гарах
сонирхолтой гэжээ.

АМЛАЛТ

Тусгай хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй
байгаа хэрэгсэлтэй

АМЛАЛТ

Ганц ч хамгаалж өгөх
бэрхдээгүй. Цахилгааны
тасардаг болсон. Гаднаар
инпортлох эрхний хүү
2 дахин нэмэгдсэн.

2016 онд 16 тэрбум
доллар байсан
гадаад ор 34 тэрбум
доллар болсон.

АМЛАЛТ

21 аймагт ирээдүйн
хүмүүнлэг ажил
түүхийн эд боловсруулах
үйлдсээр байгуулна.

Огт
хэрэгжээгүй.

АМЛАЛТ

2300 км-ээс бэлтгүүлж
зам барина.

Дарханы чиглэлийн
замыг найм дах жилдээ
барнад ордог хүртэл
дууссагүй. Өөр нэг ч
авто зам татигдаагүй.

АМЛАЛТ

Цалингийн хувиар
хувьд хувьд хувьд
бууруулна.

Энэ татвар
10-15-20%
гэж шатлан
нэмэгдсэн.

АМЛАЛТ

Ардчилсан хүний эрхийн
дээдлсэн улс бол
болгоно.

Сэтгүүлч, үг хэлсэн иргэдийн
шоронд суулдаг болсон.
Ардчилсан олон нийдсээр
үлэмж утарла.

Монгол, Венесуэл хоёр: БУРУУ ЗАМААР

Латин Америкт хөгжил, байгалийн баялгаараа тэргүүлж байсан Венесуэл орон 20 хүрэхгүй жилийн дотор бүрэн дампуурч, Африкийн хоцрогдсон орнуудтай нэг згнээнд нэгдсэн. Энэхүү гашуун явдал хэрхэн өрсөн түүхийг эх орондоо сүүлийн 8 жилд өрсөн үйл явдалтай харьцуулан харна уу. Магадгүй таныг айдас хүчиг авах биз ээ. Засгийн газар маань биднийг ийм л зүйл рүү хөтөлж байна. Үүнийг монголчууд "нохойн зам" гэдэг.

"MR 200" хувьсгалт Боливарын хөдөлгөөний үр дүн: Уго Чавес Венесуэлийн Ерөнхийлөгч болов	ТЭМЦЛИЙН ХӨДӨЛГӨӨН	"Шударга 5" тэмцлийн үр дүн: Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд болов
Уго Чавес-Цэргийн офицер Николас Мадуро-Автобусны жолооч	УДИРДАГА	У.Хүрэлсүх-Цэргийн офицер Л.Оюун-Эрдэнэ-Сэтгүүлч
PDVSA: Стратегийн гэх тодотголтой уул уурхайн 31 ордын нэгдсэн төрийн удирдлагатай компани	ТӨРИЙН САН	"Эрдэнэс Монгол": Стратегийн гэх тодотголтой уул уурхайн том ордуудын нэгдсэн төрийн удирдлагатай компани
"Bolivarian Mission" 20 жилийн хугацаанд 30 гаруй салбарт төрөөс хэрэгжүүлэх нийгмийн хөтөлбөр	НИЙГМИЙН БОДЛОГО	"Алсын хараа 2050" Бүхнийг төрөөс бүтээн байгуулах 30 жилийн бодлого
"Alo Presidente" телевиз болон чөлөөт хэвлэлүүдийг тусгай зөвшөөрөлгүй хэзээн хаав	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ	Хаалтын гэрээгээр бараг бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийг худалдаж авав. Худалдаагүйг нь шоронгоор айлгав
PDVSA: 1997-2010 онд нийт 635 тэрбум ам.долларын орлого олсон бол 2014 онд 300 тэрбум ам.долларыг хулгайд алдсан	ХУЛГАЙ	"Эрдэнэс Тавантолгой" ХК: Төрийн өмчийн тус компанид 40 их наяд төгрөгийн хулгай гарав. Нийгэмд "нүүрсний хулгай" хэмээн алдаршсан
CLAP-Local Committees for Supply and Production: Өргөн хэрэгжээний бүтээгдэхүүн бүхий хангамжийн хайрцгийг айл өрхүүдэд үнэгүй хүргэж өгөх хөтөлбөр	ИРГЭДЭЭ "ХАРЖ ҮЭЭХ" ХӨТӨЛБӨР	"Шинэ хоршоо" хөдөлгөөн: Малчдын бизнесийн орлогыг нэмэх биш, өрийн сүлжээ үүсгэн төрөөс "гинжилж" эхэлсэн. Нуран унасан социалист дэглэмийн туршилтыг дахин давтав
2005 оноос хойш засварын ажил хийгдээгүйн улмаас 2023 онд 19000 удаагийн тасалдал үүсчээ	ЭРЧИМ ХҮЧ	2016 оноос шинэ нийлүүлэлт байхгүй тул ачаалал хэтэрч, 2022 оноос цахилгааны тасалдал гарч, хязгаарлалт хийдэг болсон